



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ҮНЭНБАТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.17 № 01/29 7АТ/ТАТ/2014/02/ТА

Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж
ажиллах тухай


Монгол Улсын Ерөнхий Аудиторт УАГ-аас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн “Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-гийн аудитаар тус газраас 2013 онд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгах явцад Сэлэнгэ аймгийн прокурорын конторын барилгын ажил 76.0 хувийн гүйцэтгэлтэй гарч бүрэн хэрэгжээгүй зөрчил илэрлээ.

Сэлэнгэ аймгийн прокурорын конторын барилгын гүйцэтгэгчээр “Амарсанаа” ХХК шалгарч, “Сэлэнгэ аймгийн прокурорын газрын конторын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх” № КБ-2013/04 тоот гэрээг 2013 оны 7 дугаар сарын 10-нд мөн оны 11 дүгээр сарын 30-ний өдөр хүлээлгэн өгөх (958.0 сая төгрөг)-өөр байгуулсан боловч тайлант онд гэрээгээр гүйцэтгэх ажлаа хийж дуусаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

Он дамжин баригдаж байгаа дээрх барилгын ажлыг дуусгаж (200.0 сая төгрөг) 2014 оны 10 дугаар сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий прокурорын тамгын газрын дарга Б.Үнэнбат, Ерөнхий нягтлан бодогч Х.Галсанхүү нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



С.СЭРЧХОРОЛ
С.ОДОНЦЭЦЭГ